

어린이 국가예방접종사업 안내

ХҮҮХДИЙН ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

예방접종은 치명적인 질병으로부터 아이들을 보호할 수 있는 안전하고 효과적인 방법으로, 어린이 감염병 예방을 위해 국가에서 예방접종비용을 전액 지원하고 있습니다.

Урьдчилан сэргийлэх тарилга нь аюулт өвчнөөс хүүхдээ хамгаалах аюулгүй, үр дүнтэй арга бөгөөд хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд урьдчилан сэргийлэх вакцинжуулалт тарилгын бүх үнэ төлбөрийг улсаас хариуцаж байна.

» 국가예방접종 지원백신 **Улсаас олгож буй урьдчилан сэргийлэх вакцин**

Эрүүл чийрэг үрстэй Бүгд Найрамдах Солонгол Улс		Стандарт вакцинжуулалтын хуваарь (2022)															
Халдварт өвчин	Вакцин төрөл ба арга	Хүсн тоо	Хүснэгт 1-д өгөгдсөн өдөр	1-сар	2-сар	4-сар	6-сар	12-сар	15-сар	18-сар	19~23-сар	24~35-сар	4-н настай	6-н настай	11-н настай	12-н настай	
УЛСААС ОЛГОЖ БУЙ ВАКЦИН	Жлэх Сүрьеэ	BCG (бинол Солонгол)	1	BOC 1Н 1-д													
	B群간염 Эпалний B вирус	НерВ	3	НерВ 1Н 1-д	НерВ 2Н 2-д		НерВ 3Н 3-д										
	디프테리아 Сахуу	DTaP	5		DTaP 1Н 1-д	DTaP 2Н 2-д	DTaP 3Н 3-д			DTaP 4Н 4-д				DTaP 5Н 5-д			
	백일해 хөхүүл ханиад	Tdap/Td	1													Tdap/Td 6Н 6-д	
	폴리오 Халдварт саа	IPV	4		IPV 1Н 1-д	IPV 2Н 2-д		IPV 3Н 3-д								Tdap/Td 6Н 6-д	
	b형헤모필루스인플루엔자	Hib	4		Нб 1Н 1-д	Нб 2Н 2-д	Нб 3Н 3-д		Нб 4Н 4-д								
	6-н настай үүсгэгдсэн менингит	PCV	4		PCV 1Н 1-д	PCV 2Н 2-д	PCV 3Н 3-д		PCV 4Н 4-д								
	파임구균	PPSV	-														2-н настай өвчнөөс хамгаалах бүтэц хуваарь
	총액 Урдан бурхан	MMR	2					MMR 1Н 1-д							MMR 2Н 2-д		
	유형성대상포진	VAR	1						VAR 1Н 1-д								
	수두	VAR	1														
	A群간염 Эпалний A вирус	НерА	2							VAR 1Н 1-д							
	일본뇌염	LJEV	5									LJEV 1~2Н 1-2-д		LJEV 3Н 3-д	LJEV 4Н 4-д	LJEV 5Н 5-д	
	사말양두풍바이러스 감염증	LJEV	2									LJEV 1Н 1-д		LJEV 2Н 2-д			
	인플루엔자	HPV	2														HPV 1~2Н 1-2-д
인플루엔자	IIV	-														IIV 4-н настай жил бүр тариулах	
기타 예방접종	RV1	2						RV 1Н 1-д	RV 2Н 2-д								
예방접종	RV5	3						RV 1Н 1-д	RV 2Н 2-д	RV 3Н 3-д							

» 무료 접종 지정 의료기관

» Вакцинжуулалт тарилгыг үнэ төлбөргүй хийх магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагууд

- 지정 의료기관은 예방접종도우미 누리집 (<https://nip.kdca.go.kr>)에서 확인할 수 있습니다.
- Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагуудыг вакцинжуулалтад туслагч Нүрижиб цахим хуудас (<https://nip.kdca.go.kr>) – аас лавлаж мэдэх боломжтой.
 - * 지정 의료기관 방문 전 접종 가능한 백신 종류를 확인하시기 바랍니다.
 - * Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагад очихоосоо өмнө тариулах боломжтой вакцины төрлийг асууж лавлана уу.
 - * 지정 의료기관 정보는 한국어로 제공됩니다.
 - * Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын мэдээлэл Солонгос хэл дээр байна.
- 출생신고가 1개월 이상 지연된 경우 보건소에서 예방접종을 위한 임시관리번호를 발급받으면 무료 접종 가능합니다.
- Хүүхдийн төрсний бүртгэлийг 1 сараас дээш хийлгээгүй хоцроосон тохиолдолд харьяалах өрхийн эмнэлгээс урьдчилан сэргийлэх тарилга хийлгэхэд шаардлагатай бүртгэлийн түр дугаар авсны дараа үнэ төлбөргүй вакцинжуулалтад хамрагдах боломжтой.
- 자녀의 예방접종 기록은 예방접종도우미 누리집 또는 이동통신 앱에서도 확인할 수 있습니다. 예방접종을 완료하지 않은 경우, 가까운 보건소 또는 지정 의료기관을 방문하여 무료접종 받으시기 바랍니다. 만약 예방접종을 완료하였으나 전산등록이 누락된 경우 접종기관에 전산등록을 요청하시기 바랍니다(한국어로만 지원).
- Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан бүртгэлийг вакцинжуулалтад туслагч Нүрижиб цахим хуудас болон мобайл аппликейшнаас харж болно. Урьдчилан сэргийлэх тарилга дутуу хийгдсэн бол өөрт ойрхон өрхийн эмнэлэг болон магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагад хандан үнэ төлбөргүйгээр хамрагдана уу. Хэрэв урьдчилан сэргийлэх тарилгаа хийлгэсэн ч цахим бүртгэлд ороогүй бол тарилга хийсэн эмнэлэгтээ хандан цахим бүртгэл хийж өгөхийг хүснэ үү (Зөвхөн Солонгос хэл дээр).
- 더 궁금한 사항이 있을 때에는 인터넷 예방접종도우미 누리집 또는 이동통신 앱을 통해 확인하거나 전화로 문의주세요.
- Илүү дэлгэрэнгүй мэдээллийг интернетээр вакцинжуулалтад туслагч Нүрижиб цахим хуудас болон мобайл аппликейшн, мөн утсаар лавлана уу.

누리집: <https://nip.kdca.go.kr> | 전화번호: 043-719-8397~8399 | 다누리콜센터: 1577-1366
 Нүрижиб: <https://nip.kdca.go.kr> | Утас: 043-719-8397~8399 | Данүри лавлах төв: 1577-1366

Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэх гарын авлага

(Хосолмол соёлт гэр бүлийн асран хамгаалагчид зориулав)

1. Таны төрөлх хэл дээр байгаа “Урьдчилан сэргийлэх тарилгын хуудас”-ыг харж (Солонгос хэл дээрх) Урьдчилан сэргийлэх тарилгын хуудсыг бөглөж өгнө үү

<Урьдчилан сэргийлэх тарилгын хуудсыг бөглөхөд анхаарах зүйлс>

- Хүүхдийн нэрийг солонгос эсвэл англиар бичиж өгнө үү.
- Иргэний бүртгэлийн дугаар(гадаад иргэний үнэмлэхний дугаар)-аа бичнэ үү. Иргэний бүртгэлийн дугаар(гадаад иргэний үнэмлэхний дугаар) байхгүй тохиолдолд өрхийн эмнэлгээс урьдчилан сэргийлэх вакцин тарилга хийлгэхэд зориулан авсан “Бүртгэлийн түр дугаар”-аа бичнэ.
- Иргэний бүртгэлийн бичиг баримт дээрх төрсөн огноо болон бодит төрсөн огноо өөр тохиолдолд бодит төрсөн огноогоо холбогдох талбарт бичнэ.
 - * Тарилга хийх өдөр бодит төрсөн огноог үндэслэн тогтоодог тул бодит төрсөн огноог нотлох бичиг баримт(төрсний гэчилгээ гэх мэт)-ын хамт ойролцоох өрхийн эмнэлэгт хандан өөрчлүүлнэ үү.
- Өнөөдөр дараах шинж тэмдэг илэрч өвдсөн бол холбогдох шинж тэмдгийг сонгон бичиж өгнө үү.

- | | | | |
|----------------|------------|-------------------------|------------|
| 1. Халуурах | 2. Ханиад | 3. Хоолой өвдөх(хавдах) | 4. Гүйлгэх |
| 5. Гэдэс өвдөх | 6. Бөөлжих | 7. Толгой өвдөх | 8. Ядрах |
| | | | 9. Бусад |

2. Хүүхдийн нэрийг дуудах хүртэл эмчилгээний өрөөний гадна түр хүлээж байна уу.
3. (Тарилга хийхийн өмнө) Өмнө нь ижил төрлийн тарилга хийлгэсэн эсэхийг хүүхдийн вакцинжуулалтад хамрагдсан бүртгэлийг лавлаж үзнэ.
 - ※ Эмч хүүхдийн тарилга хийлгэж байсан бүртгэлийг цахим системээр шалгаж болно.
 - ※ Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын бүртгэлийн дэвтэр байгаа бол эмчид өгнө үү.
4. (Тарилга хийхийн өмнө) Эмчийн тайлбарлан хэлж байгаа урьдчилсан үзлэг ба гаж нөлөөг сайн сонсож авна.
 - ※ Солонгос хэл ойлгоход хэцүү бол эмчдээ төрөлх хэл дээр байгаа урьдчилан сэргийлэх тарилгын гарын авлага(VIS)-ыг хэвлэж өгөхийг хүсэн гарын авлага дахь “Урьдчилан сэргийлэх тарилгын дараа анхаарах зүйлс ба гаж нөлөө” хэсгийг сайтар уншина.
5. (Тарилга хийх үед) Эмч тариагаа зөв сайн хийж чадахаар хүүхэд уйлан эсэргүүцвэл асран хамгаалагч хүүхдээ өвөр дээрээ суулгаж нэг гараараа хүүхдийн их биеийг тэврэнэ.
6. (Тарилга хийх үед) Урьдчилан сэргийлэх тарилгын өмнө болон дараа анхаарах ёстой зүйлсийг сайн сонсон авч, тариагаа хийлгэнэ.
7. (Тариулсны дараа) Хүүхдийн дараагийн тариулах өдрийг эмчтэй зөвлөн тогтоно.
 - * Урьдчилан сэргийлэх тарилгын хуудас бөглөхдөө “Гар утасны дугаараар мессэж хүлээн авахыг зөвшөөрсөн” -ийг сонгож, эмчид мессэж хүлээн авах хэлээ хэлж өгвөл дараагийн тарилгаас эхлэн солонгос хэлнээс гадна хүссэн хэлээр тань “Дараагийн тарилгын нэр болон тариулах өдөр”-ийг мессэжээр явуулан мэдэгдэх болно. Хүссэн хэлээ сонгож дараагийн вакцин тариулах өдрийг мэдэгдэх мессэж хүлээн авах өөр нэг асран хамгаалагчийн утасны дугаарыг нэмж бүртгүүлж болох юм.
8. (Тарилгын дараа) Эмнэлэгт 20-30 минут байж гаж нөлөө гарах эсэхийг ажиглана.
9. (Гэртээ хариад) Хамгийн багадаа 3 цагаас дээш хугацаагаар маш анхааралтай ажиглаж халуурах эсвэл ердийн үед биед гарч байгаагүй шинж тэмдэг илэрвэл яаралтай эмчид үзүүлэх хэрэгтэй.
 - ※ Вакцин тариулахтай холбоотой орчуулга хэрэг болсон тохиолдолд Данүри лавлах төв(☎ 1577-1366) руу холбогдож тусламж авч болно.



Вакцин хийлгэх бүртгэл

Аюулгүй вакцин хийлгэхийн тулд доорх асуултыг уншин, өөрийн биеэр (хуулийн бие төлөөлөгч болон асран хамгаалагч) бөглөнө үү.

Овог нэр		Иргэний үнэмлэхний дугаа	-	(□эр □эм)
Төрсөнөн сар өдөр		гадаад иргэн ий үнэмлэхний дугаар	-	(□эр □эм)
Утасны дугаар	(Гэрийн утас)	(Гар утас)	Биеийн жин	kg

Вакцин хийлгэхэд шаардлагатай хувийн мэдээлэлийн талаарх зөвшөөрсөн зүйлс	өөрийн бие (хуулийн бие төлөөлөгч, асран хамгаалагч) <input checked="" type="checkbox"/>
---	--

“Халдварт өвчинтэй тэмцэх урьдчилсан сэргийлэх тухай хуул”ийн зүйл мөн хуулийг хэрэгжүүлэх тогтоолын 32-ын3дугаар зүйлд заасны дагуу иргэний үнэмлэхний дугаар хувийн мэдээлэл болон эмзэг мэдээллийг цуглуулж байна. Дараахи зүйлийг нэмж цуглуулах болно.

- Хувийн мэдээллийг цуглуулах зорилго :Зайлшгүй хийлгэх шаардлагатай вакцины давтамжийн вакцинжуулалтыг дуусгасан эсэх, вакцин хийлгэсний дараа сөрөг нөлөө илэрсэн эсэхтэй холбогдолтой мэссэж
- Хувийн мэдээллийг цуглуулах ашиглах зүйлс: Хувийн мэдээлэл (эмзэг мэдээлэл, иргэний үнэмлэхний дугаар оруулах), утасны дугаар (гэр болон гар утас)
- Хувийн мэлээллийг хадгалах болон ашиглах хугацаа: 5жил

Вакцин хийлгэхээс өмнө вакцинд хамрагдагчийн вакцины жагсаалт болон урьдчилсан сэргийлэх вакцины нэгдсэн хяналтын системээс урьдчилан шалгахыг зөвшөөрч байна.
* Вакцины жагсаалтаас урьдчилан шалгахыг зөвшөөрөөгүй тохиолдолд, шаардлагагүй нэмэлт вакцин болон вакцинаа давхцуулах тохиолдол гарч болно

тийм үгүй

Зайлшгүй хийлгэх шаардлагатай вакцины давтамж вакцин болон дууссан эсэх талаарх мэдээллийг гар утсаараа мэссэж авахыг зөвшөөрч байна
* Мэссэж авахыг зөвшөөрөөгүй тохиолдолд, зөвшөөрөөгүй зүйлсийн талаарх мэдээллийг хүлээн авах боломжгүй.

тийм үгүй

Вакцин хийлгэсний дараа сөрөг нөлөө илэрсэн эсэхтэй холбогдолтой мэссэжийг гар утсаараа авахыг зөвшөөрч байна.
* Мэссэж авахыг зөвшөөрөөгүй тохиолдолд, зөвшөөрөөгүй зүйлийн талаарх мэдээллийг хүлээн авах боломжгүй .

тийм үгүй

Вакцинд хамрагдах хүний талаарх мэдээлэл	өөрийн бие (хуулийн бие төлөөлөгч, асран хамгаалагч зөвшөөрөх) <input checked="" type="checkbox"/>
--	--

Өнөөдөр хаана чинь өвдөж байна вэ? Өвдөж байгаа газрынхаа шинж тэмдгийг бичнэ үү.
()

тийм үгүй

Эм болон хоол(өндөг) мөн вакцинаас үүдэлтэй биеэр туурах юмуу харшлын шинж тэмдэг илэрч байсан уу?

тийм үгүй

Өмнөх вакциныдараабиедямарнэгэнсөрөгнөлөөилэрчбайсануу? Тиймболбичнэүү.
(Вакцины нэр)

тийм үгүй

Төрөлхийн согог, багтраа болон уушиг, бөөр, зүрх, элэг, чихрийн шижин болон дотоод шүүрлийн, цусны өвчтэй болон эмчилгээ хийлгэж байсан удаа бий юу? Тийм бол бичнэ үү.

тийм үгүй

Татаж байсан эсвэл тархи, мэдрэлийн ямар нэг эмгэгтэй юу?

тийм үгүй

Хортхавдар,цусныцагаанөвчинболондархлаатайхолбоотойөвчинтэйюу?Бичнэүү. (Өвчнийнэр:)

тийм үгүй

Сүүлийн 3 сарын дотор стройд, антибиотик, цацраг туяан эмчилгээ хийлгэсэн үү?

тийм үгүй

Сүүлийн 1 жилд цус сэлбэх юм уу, дархлаа сайжруулах глобулин хийлгэсэн үү?

тийм үгүй

Сүүлийн 1 сард вакцин хийлгэсэн уу? Тийм бол вакцины нэрээ бичнэ үү. (Вакцины нэр :)

тийм үгүй

(Эмэгтэй хүнд) Одоо жирэмсэн буюу сарын дотор жирэмслэх магадлалтай юу?

тийм үгүй

Эмчийн үзлэг болон вакцины дараа нэг шинж илэрч болох талаар тайлбарласы дараа вакцин хийнэ.
Өөрийн(хуулийн бие төлөөлөгч, асран хамгаалагч) нэр : (Гарын үсэг) Ямар холбоотой болох :
Бүртгэл хийгдээгүй нярай бол хуулийн бие төлөөлөгчийн үнэмлэхний дугаар (-)
он сар өдөр

Эмчийн үзлэгийн бүртгэл (Эмч бөглөх хуудас)	Отметьте! <input checked="" type="checkbox"/>
---	---

Биеийн халуун : °C Вакцины дараах шинжийн талаар тайлбарласан.

Вакцин хийлгээд 20-30 минут ажиглаж байгаад явах талаар тайлбарласан.

Үзлэгийн үр дүн :

Эмчийн үзлэгээр вакцин хийхэд боломжтой. Эмчийн нэр : (гарын үсэг)

자녀의 예방접종 기록을 확인하세요.

Хүүхдийнхээ урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн бүртгэлийг шалгаж байгаарай.

■ Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн бүртгэл цахим системд бүртгэгдвэл ямар сайн талтай вэ?

1. Хүүхдийнхээ урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн бүртгэлийг вакцинжуулалтад туслагч Нүрижиб цахим хуудас (<https://nip.kdca.go.kr>) болон мобайл аппликейшнээр шалгах боломжтой болно.
 - Вакцинжуулалтад туслагч Нүрижиб (<https://nip.kdca.go.kr>) цахим хуудаст гишүүнээр элсэн хүүхдээ бүртгүүлнэ.
 - Вакцинжуулалтад туслагч Нүрижиб нэвтрэх → [Урьдчилан сэргийлэх тарилга] → [Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга] → [Хүүхдийн мэдээллээ бүртгүүлэх]
 - Бүртгэлтэй хүүхдийн тарилга хийлгэсэн байдлыг дараах аргаар шалгана.
 - Вакцинжуулалтад туслагч Нүрижиб → [Урьдчилан сэргийлэх тарилга] → [Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга] → [Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын түүх лавлах]
 - Вакцинжуулалтад туслагч мобайл аппликейшн → [Манай хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга] → [Хүүхдийн дэвтэр]
 - * Мобайл аппликейшн нь “Вакцинжуулалтад туслагч Нүрижиб”-д гишүүнээр бүртгүүлж хүүхдийн мэдээлэлорсны дараа ашиглах боломжтой.
 - ※ Урьдчилан сэргийлэх тарилга хийсэн тэмдэглэл бүртгэгдээгүй тохиолдолд тарилга хийлгэсэн эмнэлэгтээ хандан цахим системд бүртгэл хийж өгөхийг хүснэ.
 - ※ Урьдчилан сэргийлэх тарилгын бүртгэлийн дэвтэр нь асран хамгаалагч хүүхдийн тарилга хийлгэсэн байдлыг удирдахад тусалж өгдөг тул вакцин хийлгэснийг нотлох тодорхойлолт бичиг баримтыг орлодоггүй болно.
2. Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэснийг нотлох тодорхойлолтыг онлайнаар үнэ төлбөргүй(солонгос болон англи хэлээр) авч болно.
 - Вакцинжуулалтад туслагч Нүрижиб нэвтрэх → [Цахим хүсэлтийн үйлчилгээ] → [Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тодорхойлолт]
3. Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга хийлгэх өдрийг мартуулахгүйн тулд дараагийн тарилга хийлгэх өдрийг мессэжээр мэдэгдэж өгч байна.
 - Эмчид холбоо барих боломжтой эцэг эх(асран хамгаалагч)-ийн гар утасны дугаарыг өгч, зайлшгүй хийлгэх вакцин тарилгын өдрийг мессэжээр мэдэгхамгаалагчдэн өгч байна.
 - Хэрэв гадаад хэлээр мессэж хүлээн авахыг хүсвэл эмчид хүлээн авах гадаад хэлээ мэдэгдэнэ. Солонгос хэлтэй хамт сонгосон гадаад хэлээр мессэж авч болно. Мөн дараагийн вакцин хийлгэх өдрийг өөр асран хамгаалагч мессэжээр давхар авч байхаар гар утасны дугаарыг нь нэмж бүртгүүлж болно.

■ Гадаад улс оронд тарилга хийлгэсэн хүүхдийн хувьд урьдчилан сэргийлэх тарилга хийлгэснийг нотлох тодорхойлолт баримтыг ирэхээсээ өмнө гаргуулан авч ирнэ үү.

Гадаад улсад удаан хугацаагаар оршин сууж байгаад Солонгост ирсэн бол ирэхээсээ өмнө “Англи хэл дээрх урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тодорхойлолт” болон “Тарилга хийсэн байгууллагын албан ёсны гарын үсэг эсвэл тамга(Official Signature or Stamp)-тай баримт”-ыг гаргуулан авч ойролцоох өрхийн эмнэлэгт хандан цахим системд бүртгүүлнэ үү.

БНСУ-д нэг дор олноор цуглардаг сурагчдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор цэцэрлэг болон бага дунд сургуульд элсэн ороход урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тодорхойлолтыг шаардаж вакцинаа бүрэн хийлгэсэн эсэхийг шалгадаг.

Гэхдээ БНСУ-ын Өвчний хяналт удирдлагын төвийн цахим системд бүртгэгдсэн бол цэцэрлэг, сургуульд тодорхойлолт өгөх шаардлагагүй юм.

* Үндэслэл : 「Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт удирдлагын тухай хууль」 31-р зүйл, 「Сургуулийн эрүүл ахуйн тухай хууль」 10-р зүйл, 「Бага насны хүүхдийн боловсролын тухай хууль」 31-р зүйлийн 3-р хэсэг

ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГЫН ХӨТӨЛБӨР

국가예방접종 지원사업

» ХҮҮХДИЙН ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГЫН ХӨТӨЛБӨР

Урьдчилан сэргийлэх тарилга нь халдварт өвчнөөс ард иргэдээ хамгаалах зорилгоор заавал хийлгэх вакцин тарилгын бүх төлбөрийг улсаас хариуцаж байна.

- Хамрагдах хүрээ : 12 нас хүртэлх хүүхэд
 - ※ Хамрагдах хүүхэд өөрт ойр эрүүл мэндийн төв эсвэл магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагад хандана уу.
- Улсаас хариуцах вакцины төрөл : 17 төрлийн вакцин

Сүрьеэ(BCG, Судас тариа), Элэгний В вирус(НерВ), Сахуу/Татранги/Хөхүүл ханиад(DTaP), Татранги/Сахуу(Td), Татранги/Сахуу/Хөхүүл ханиад(Tdap), Халдварт саа(IPV), Сахуу/Татранги/Хөхүүл ханиад/Халдвар саа (DTaP-IPV), Сахуу/Татранги/Хөхүүл ханиад / Халдвар саа/Б нянгаар үүсгэгдсэн менингит(DTaP-IPV/Hib), Б нянгаар үүсгэгдсэн менингит(Hib), Уушгины хатгаа(PCV), Улаан бурхан/Улаанууд/Гахайн хавдар(MMR),Салхин цэцэг(VAR), Японы тархины үрэвсэл сулруулсан вакцин(IJEV), Японы тархины үрэвсэл амьд вакцин(LJEV), Элэгний А вирус(НерА), Умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч вирус(HPV), Хөхүүл ханиад(IIV)

※ Элэгний А вирус, уушгины хатгаа зэрэг зарим төрлийн вакцин нь үнэгүй тариулах насны хязгаартай болно.

- Тарилга хийх байгууллага : Өөрт ойр магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллага болон эрүүл мэндийн төв
 - ※ Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагыг хайх : Урьдчилан сэргийлэх тарилга вакцинжуулалтад туслагч Нүрижиб(<https://nip.kdca.go.kr>) цахим хуудас болон вакцинжуулалтад туслагч мобайл ликейшнаас

» Элэгний В вирус жирэмсний болон төрсний дараах халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Элэгний В вирустэй эхээс төрсөн нярай хүүхэд В вирус халдварлахаас урьдчилан сэргийлж төрөх үед дархлаа сайжруулагч глобулин болон В вирусээс урьдчилан сэргийлэх вакцин тарилга хийх, эсрэг биетийн шинжилгээ хийх бүх зардлыг улсаас хариуцаж байна.

- Хамрагдах хүрээ

В вирусын халдвар антиген(НВsAg) эсвэл е антиген(НВеAg) эерэг гарсан эхээс төрсөн нярай нараас жирэмсэн үедээ төрхөөс өмнөх В вирусын шинжилгээний хариугаа* гарган өгсөн болон хувийн мэдээллээ өгөхийг зөвшөөрсөн хүн

* Жирэмсний үед болон төрсний дараах 7 хоног дотор эхэд хийгдсэн В вирусын халдвар антиген(НВsAg) эсвэл е антиген(НВеAg) шинжилгээний хариу эерэг гарсан
- Тусламжийн агуулга

Дархлааны глобулин 1 удаа(төрөх үед), үндсэн вакцин тарилга 3 удаа(0, 1, 6 сартайд), үндсэн вакцин тарилгын дараа В вирусны антиген, эсрэг биетийн шинжилгээ 1 удаагийн бүх зардлыг улсаас хариуцна.

※ 1 дэх удаагийн антиген, эсрэг биетийн шинжилгээний үр дүнгээс шалтгаалж давтан тарилга(дээд тал нь 3 удаа) болон давтан шинжилгээ(дээд тал нь 2 удаа)-ний зардлуудыг нэмж хариуцаж болно.

ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГЫН ХӨТӨЛБӨР

국가예방접종 지원사업

» Эрүүл эмэгтэй анхны алхам клиник хөтөлбөр

Биеийн болон сэтгэл зүйн их өөрчлөлтийг туулж өнгөрүлэх амьдралын шилжилтийн үеийн өсвөр насны охидуудад нарийн мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах, үзлэг хийлгэх, умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч вирус(HPV)-с урьдчилан сэргийлэх тарилга хийх үйлчилгээг хамт үзүүлж байгаа бөгөөд эрүүл эмэгтэй болон өсч торниход дэмжлэг үзүүлж байна.

- Хамрах хүрээ : 12 нас бүрэн хүрсэн охид

- ※ Хамрагдах илүү дэлгэрэнгүй мэдээллийг ойролцоох дүүрэг хорооны эрүүл мэндийн төв болон магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагаас тодруулна уу.

- Тусламжийн агуулга

Умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч вирус(HPV)-с урьдчилан сэргийлэх вакцин тарилга болон өсвөр насны охидуудын эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, 6 сарын хугацаатай 2 удаа үнэгүй дэмжлэг үзүүлэх.

- Вакцин : Гардашил(HPV4), Серваригс(HPV2)

» Хөхүүл ханиад томууны Үндэсний урьдчилан сэргийлэх тарилгын хөтөлбөр

Хөхүүл ханиад хүрсэн үед хавсармал өвчин тусах өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарах өндөр настан, жирэмсэн эхчүүд, олноороо нэг дор сурдаг бага насны болон өсвөр насныхан хөхүүл ханиаднаас урьдчилан сэргийлэх, олноор халдварлан тархахаас сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх вакцин тарилгын зардлыг улсаас бүрэн хариуцаж байна.

- Хамрах хүрээ : Бага насны хүүхэд, 65 дээш насны өндөр настан, жирэмсэн эхчүүд

- ※ Хамрагдах илүү дэлгэрэнгүй мэдээллийг ойролцоох дүүрэг хорооны эрүүл мэндийн төв болон магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагаас тодруулна уу.

- Тусламжийн агуулга : Хөхүүлэн ханиадны вакцин тарилга 1 удаа

- ※ 9 нас бүрэн хүрсэн хүүхэд хөхүүл ханиадны вакцин анх удаа тариулж байгаа бол доод тал 4 долоо хоногос дээш хугацаатай завсарлаж 2 удаа тариулна.

- ※ Үнэгүй вакцин тарилга хийлгэх хугацаа, тавигдах шаардлага зэрэг илүү дэлгэрэнгүй мэдээллийг оршин сууж буй дүүрэг хорооны эрүүл мэндийн төв болон магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагад хандана уу.



Бага дунд сургуульд элсэн орогч сурагчийн вакцинд хамрагдсаныг шалгах хөтөлбөр

초 · 중학교 입학생 예방접종 확인사업

» Бага дунд сургуульд элсэн орогч сурагчийн вакцинд хамрагдсаныг шалгах хөтөлбөр

Олноороо нэг дор байдаг хүүхэд багачуудын хувьд халдварт өвчин тархахад эмзэг байдаг тул бага дунд сургуульд шинээр элсэн орсон сурагчдын нийт бүлгийн дархлаажуулалтыг сайжруулах зорилгоор вакцин тарилгад бүрэн хамрагдсан эсэхийг шалгаж хамрагдаагүй сурагчийг хяналтанд авч тарилга хийлгэж бүртгэлжүүлэхийг дэмжиж байна.

* 「Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын тухай хууль」 31-р зүйл, 「Сургуулийн эрүүл мэндийн тухай хууль」 10-р зүйл

- Хамрах хүрээ : Бага болон дунд сургуульд элсэн орж буй бүх хүүхэд

- Шалгах вакцины төрөл

- (Бага сургуульд элсэн орох хүүхэд) 4-6 нас бүрэн хүрсэн 4 төрлийн вакцин

DTaP 5 дах удаагийн , IPV 4 дэх удаагийн, MMR 2 дахь удаагийн, Японы тархины үрэвсэл (сулруулсан вакцин 4 дэх удаагийн мөн амьд вакцин 2 дахь удаагийн)

- (Дунд сургуульд элсэн орох хүүхэд) 11 - 12 нас бүрэн хүрсэн 3 төрлийн вакцин

Tdap(эсвэл Td) 6 дахь удаагийн, Японы тархины үрэвсэл (сулруулсан вакцин 5 дахь удаагийн мөн амьд вакцин 2 дахь удаагийн), HPV 1 дэх удаагийн(эмэгтэй сурагчид хамаарна)

- Хөтөлбөрийн арга зүй

Боловсролын яамны Бага дунд сургуульд элсэн орогчийн мэдээлэл болон Өвчний Хяналт Урьдчилан Сэргийлэх Агентлаг урьдчилан сэргийлэх тарилгын мэдээллийг харьцуулан судалж хөтөлбөрийн дагуу вакцин бүрэн хийлгэсэн эсэхийг шалган, вакцин тарилга хийлгээгүй тохиолдолд хийлгэхэд туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

* Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн мэдээллийг вакцинжуулалтад туслагч Нүрижиб цахим хуудас болон мобайл аппликейшнаас шалгах боломжтой бөгөөд цахим бүртгэлд мэдээлэл орсон бол <Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн хуудас>-ыг сургуульдаа өгөх шаардлагагүй.

* <Вакцин тарилга хориотой сурагч> бол онош(тарилга) гаргасан эмнэлгийн байгууллагаас <Вакцин тарилга хориотой шалтгаан>-ыг цахим бүртгэлд оруулахыг хүснэ. Хэрэв эмнэлгийн байгууллага <Вакцин тарилга хориотой шалтгаан>-ыг цахим бүртгэл хийх боломжгүй тохиолдолд <Вакцин тариа хориотой шалтгаан>-ыг заасан оношлогооны хуудас авч сургуульдаа өгнө.

▶ Вакцин тарилга хориотой сурагч

- Вакцины найрлагад орсон бодис, мөн өмнө хийсэн вакцин тарилгын дараа цочмог харшил (анафилакс) өгсөн тохиолдолд
- Хөхүүл ханиадны вакцин тариулснаас хойш 7 хоногийн дотор ямар нэг шалтгаангүйгээр тархины өвчин зовиур гарсан бол
- Дархлааны дутагдалтай болон дархлаа дарангуйлагч эм хэрэглэгч

* Өндөр халуун, дархлааны глобулин тариулах зэрэг түр зуурын шалтгаантай, өндөгний харшил болон арьсны харшил атопи зэрэг нь вакцин хорих шалтгаан болохгүй.



어린이가 건강한 대한민국 (목표)

질병관리청
보건복지부
KMA

대한의사협회
대한예방접종학회
KMA

예방접종전문위원회
백신접종관리위원회
KMA

Эрүүл чийрэг үрстэй Бүгд Найрамдах Солонгол Улс

표준예방접종일정표(2022) Стандарт вакцинажуулалтын хуваарь (2022)

대상감염병 Халдварт өвчин	백신종류 및 방법 Вакцин төрөл ба арга	Хүсн Тоо	Төрсөн Төрийн саяхын дотор	1 га сар	2 га сар	4 га сар	6 га сар	12 га сар	15 га сар	18 га сар	19~23 га сар	24~35 га сар	4 на сар	6 на сар	11 на сар	12 на сар
결핵 Сурьээ	BCG (피내용) Сурьстэриг	1	БСГ 1 х 1 удаа													
B형간염 Элэгний B вирус	НерВ	3	НерВ 1 х 1 дахь	НерВ 2 х 2 дахь												
디프테리아 Сахуу 파상풍 татранги 백일해 хөхүүл ханиад	DTaP	5	DTaP 1 х 1 дахь	DTaP 2 х 2 дахь	DTaP 3 х 3 дахь	DTaP 4 х 4 дахь	DTaP 5 х 5 дахь									
폴리오 Халдварт саа	Tdap/Td	1														Тсар/Tд 6 х 6 дахь
인플루엔자 Хөхүүл ханиад	IPV	4	IPV 1 х 1 дахь	IPV 2 х 2 дахь	IPV 3 х 3 дахь	IPV 4 х 4 дахь	IPV 5 х 5 дахь									
백신 Бүтээгдэхүүн	Hib	4	Hib 1 х 1 дахь	Hib 2 х 2 дахь	Hib 3 х 3 дахь	Hib 4 х 4 дахь										
백신 Бүтээгдэхүүн	PCV	4	PCV 1 х 1 дахь	PCV 2 х 2 дахь	PCV 3 х 3 дахь	PCV 4 х 4 дахь										
백신 Бүтээгдэхүүн	PPSV	-														
백신 Бүтээгдэхүүн	MMR	2						MMR 1 х 1 дахь						MMR 2 х 2 дахь		
백신 Бүтээгдэхүүн	VAR	1						VAR 1 х 1 дахь								
백신 Бүтээгдэхүүн	НерА	2														
백신 Бүтээгдэхүүн	IJEV	5														
백신 Бүтээгдэхүүн	LJEV	2														
백신 Бүтээгдэхүүн	HPV	2														HPV 1~2 х 1-2 дахь
백신 Бүтээгдэхүүн	IIV	-														
백신 Бүтээгдэхүүн	RV1	2														
백신 Бүтээгдэхүүн	RV5	3														

- 국가예방접종:** 국가에서 권장하는 필수예방접종(국가 「감염병의 예방 및 관리에 관한 법률」을 통해 예방접종 실시기준 및 방법을 정하고, 이를 근거로 재원을 마련하여 지원하고 있음)을 통해 실시되는 예방접종이다. 국가에서 권장하는 필수예방접종(국가 「감염병의 예방 및 관리에 관한 법률」을 통해 예방접종 실시기준 및 방법을 정하고, 이를 근거로 재원을 마련하여 지원하고 있음)을 통해 실시되는 예방접종이다.
- 기타예방접종:** 예방접종 대상 감염병 및 지정감염병 이외 감염병으로 민간 의료기관에서 접종 가능한 유료 예방접종이다. 예방접종 대상 감염병 및 지정감염병 이외 감염병으로 민간 의료기관에서 접종 가능한 유료 예방접종이다.
- 백신:** 백신은 예방접종일정에 따라 DTaP-IPV 또는 DTaP-IPV/Hib 혼합백신으로 접종 가능하다. 백신은 예방접종일정에 따라 DTaP-IPV 또는 DTaP-IPV/Hib 혼합백신으로 접종 가능하다.

DTaP, IPV, Hib 백신은 예방접종일정에 따라 DTaP-IPV 또는 DTaP-IPV/Hib 혼합백신으로 접종 가능하다. DTaP, IPV, Hib 백신은 예방접종일정에 따라 DTaP-IPV 또는 DTaP-IPV/Hib 혼합백신으로 접종 가능하다.